

ЖИГМЭДДАНЗАНЖАМЦ (ЗОРИГТ ВАН)-ИЙН НАМТАР, БҮТЭЭЛИЙН СУДАЛГАА

Н.Гансүх, Ш.Болд
Эм зүйн шинжлэх ухааны их сургууль

A STUDY ABOUT JIGMEDDANZANJAMTS'S (THE BRAVE KING) BIOGRAPHY AND BOOKS COMPOSED BY HIM

Gansukh N., Bold Sh.
Mongolian University of Pharmaceutical Sciences

Introduction:

Jigmeddanzanjamts was a person who was born in the east Sonod Land of Shiliin Gol province in Inner Mongolia (presently the East Sonod Khoshuu of Inner Mongolian Autonomy in People's Republic of China). He has lived at the end of 19th century and at the beginning of the 20th century. At his childhood age, he has stayed in the Jari Temple (also called the Great Generous Temple) and studied Tibetan language. He was talented in learning Tibetan language. He also deeply studied Buddhist philosophical teachings in The Philosophical lineage temple and obtained Geshe rank which is a kind of scientific scholar's title. He was renowned by his Temple name as "Jari Geshe".

Besides, this achievement, he was a Tulku and worked as abbot of a temple. It was mentioned at the end of his book called "Joys of Realizers" that "This book was composed by the Tulku Jigmeddanzanjamts the Brave-Hearted King".

Materials and methods

He divided his book into 5 sections and in the first section he provided a detailed description about the urine analysis and diagnostics by sensing pulse of a patient. In the second section, he summarized only the capability of 348 types of medicines. In the third section, he classified various diseases into 80 categories and determined specific methods for curing each disease such as internal disease, bacteria, diseases of the womb and internal organs such as liver, kidney, lung, heart and spleen, skin disease, gynecopathy, childhood disease, other injuries. In the fourth section, he wrote about how to reduce power of 22 types of medicines, and how to substitute 32 types of medicines. In the fifth section, he provided a detailed information about 316 types of prescriptions, and doses of medicine shall be included in each prescription, method for blending those prescriptions.

Results: He also included the prescription of medicines used in Chinese hospitals in his book. For example, he mentioned that "Kindly find the Lin or Dan prescription from Chinese hospitals" in his book. The book called "Joys of Realizers" can be considered as a distinguished book from another book by its content and meaning side. In fact, it greatly depends from the author's wider way of thinking, his enormous practical experience and knowledge.

Conclusion: From this book, it is obviously observable that he always treated each disease, from the point of seeing in a complex rather than seeing only the disease. Especially, the list, which listed organs of a human body as brain, eye, ear, nose, etc. from top to down part have not observed in other books published in the preceding period. Therefore, it can be considered that the book has some new categories that has not introduced before in books have been composed and published before.

Key words: The Brave King , Jigmeddanzanjamts "Jari Geshe".

Судалгааны ажлын үндэслэл:

Жигмэдданзанжамц нь Өвөр Монголын Шилийн голын чуулганы зүүн Сөнөд хошуунд

(Одоогийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн зүүн Сөнөд хошуу) төрсөн, XIX зууны сүүлч XX зууны эхээр амьдарч байсан

хүн ажээ. Бага наснаасаа хошууныхаа Жари сүмд (мөн Өглөг ихэт сүм гэдэг) шавилан сууж төвөд үсэг, бичиг заалган уг хэлийг гарамгай сурахын зэрэгцээ чойрын дацанд суралцаж буддын гvн ухааныг сайтар эзэмшиж улмаар гэвш хэмээх эрдмийн цол хамгаалж өөрийн сүмийн нэрээр “Жари гэвш” гэж алдаршжээ. Түүнчлэн шавран хvн байсан бөгөөд хийдийн хамбын алба хашиж байв. Энэ талаар өөрийнх нь бичсэн “Үзэгсдийн баясгалан” гэдэг зохиолын төгсгөлд: “Зоригт хамбын цолт, шавран Жигмэдданзанжамц бээр найруулан зохиовой” гэж тэмдэглэжээ.

Зорилго: “Үзэгсдийн баясгалан” судрын зохиогчийн намтар, судрын өмнөх шүлгийн онцлог, уг судар дахь хятад анагаах ухааны эм найрлагын хэрэглээ, зарим эм найрлагын бүтэц, бүрэлдхүүнийг тодруулах зорилго тавина.

Зорилт: Зорилгоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавилаа.

1. “Үзэгсдийн баясгалан” судрын зохиогчийн намтар, идэр, хижээл насны амьдрал, бүтээлийн талаарх мэдээллийг тодруулах;

2. “Үзэгсдийн баясгалан” судрын эхлэл шүлэг, уг шүлгийн агуулга, мөн чанарыг тогтоох;

3. “Үзэгсдийн баясгалан” судар дахь хятад анагаах ухааны эмийн түүхий эд, эм найрлагыг түүвэрлэн, хэрэглээний хүрээг судлах;

4. “Үзэгсдийн баясгалан” судар дахь хятад анагаах ухааны зарим өргөн хэрэглэгдэж, байсан, өнөө ч үнэ цэнээ алдаагүй байгаа зарим эм найрлагын бүтэц, бүрэлдхүүн, хэрэглээг харьцуулан тогтоох;

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн, арга зүй:

Уг судалгааны арга нь сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг, нэрийн хэлхээ зэргийг нэгэн дор хамтатган судлахад оршдог. Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилго, зорилтуудад нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацааг хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлж, намтар, түүхийн судалгааг хийн улмаар бүтээлийн гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан,

шүүн тунгааж үзлээ. Мөн зохиолын дотор агуулагдах эмийн ухаантай шууд холбоотой мэдээ, сурвалжийг сонгон авч цаг хугацааны дараалалд оруулан бусад бүтээлийн мэдээллээр баяжуулан оюун дүгнэлт хийв. Монголын уламжлалт анагаах ухааны сурвалж бичгийн дотор алдартай эмч нарын намтартай холбоотой мэдээ сэлт баялаг байдаг билээ. Тиймээс түүхэн хүмүүсийн амьдрал, бүтээлийг эх бичгийн судлалд түшиглэн тодруулах боломжтой юм.

Дүгнэлт:

1. Зоригт ван Жигмэдданзанжамц нь Монголын анагаах ухааны нэрт зүтгэлтэн болохыг түүний намтар, бүтээлээс тодруулан “Үзэгсдийн баясгалан” судар нь хөрш зэргэлдээ орны анагаах ухааны мэдлэгээр баяжуулан бичсэн, практикийн чухал ач холбогдолтой зохиол юм.

2. “Үзэгсдийн баясгалан” судрын эхлэл шүлгийн агуулга, мөн чанар ялангуяа Зоригт ван Жигмэдданзанжамцийн үзэл бодол, итгэл үнэмшил, шүтлэг, үүгээр дамжуулан биеийн өвчнөөс гадна сэтгэлийн өөрчлөлтийг Оточ манал бурханд итгэл, мөргөл одуулснаар тэнцвэржүүлж болохыг ойлгуулсан агуулгатай болох нь тогтоогдов.

3. “Үзэгсдийн баясгалан” судар дахь хятад анагаах ухааны эмийн түүхий эд, эм найрлага нийт 30-ыг түүвэрлэн авч жагсаалт хийн, тэдгээрийн хэрэглээний хүрээг тодруулахын зэрэгцээ зарим жорыг өнөөдөрч эмнэлгийн практикт хэрэглэх боломжтой гэдгийг тодруулав.

4. “Үзэгсдийн баясгалан” судар дахь балисан, чилисан эмийг өнөөгийн хятад анагаах ухааны ижил эмтэй найрлага, хэрэлээг харьцуулан судалж цаашид үйлдвэрлэх нөхцлийг бүрдүүлэв.

Ном зүй

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, тал 16

2. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 4 боть, УБ, 2013

3. Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч академич Ш.Болд, академич Д.Цэрэнсодном) УБ, 2014, х.24

4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. УБ, 2014, х.7

5. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Тэргүүн боть, дэд боть, гутгаар боть, дөтгөөр боть. УБ, 2013

6. Бай Буянт. Хүннүгийн анагаах ухааны түүхийн судалгаа. Анагаах ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. УБ, 2006

7. Бай Буянт. Хүннүгийн анагаах ухааны түүхийн судалгаа. Анагаах ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. УБ, 2006

8. Жигмэд Б. Монгол анагаах ухааны түүх, ӨМ, ШУТМ Хэвлэлийн хороо, 2002.

9. Рашид ад Дин, "Судрын чуулган", 2002, 98-р тал

10. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Гутгаар боть (1206-1578 он хүртэл). УБ, 2013

11. Жнованни Дель Плано Карпини., Гильем де Рубрук. Монголчуудын түүх, Дорно этгээдэд зорчсон мннь, УБ, УХГ, 1988.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор Л.Уламбаяр*